



ГАЗРЫН ХАРИЛЦАА, ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ




Газрын харилцаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл нь иргэдийн хувьд хамгийн түгээмэл тохиолддог 3 асуудлын нэг ажээ. Нийт судалгаанд оролцогчдын 13,8 хувь буюу 226 иргэнд дээрх бэрхшээл тулгарчээ. Эдгээр бэрхшээлийн дийлэнх хэсэгт нь газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олж авах, тус эрхийг хүчингүй болгох асуудал эзэлж байна.



Дээрх бэрхшээл тархалтын хувьд Улаанбаатар хотод хамгийн их буюу 40,3 хувь, харин аймгийн төв болон сумдад 24-35 хувьтай байна.




Газартай холбоотой бэрхшээлээ шийдвэрлэх талаар иргэдийн 57,4 хувь нь ямар нэг оролдлого хийсэн бол 42,6 хувь нь ямар ч оролдлого хийлгүй орхисон байна. Үүний шалтгааныг дараах графикаас харна уу.




Газартай холбоотой бэрхшээлээ шийдвэрлэх гэж оролдсон иргэдийн 58,1 хувь нь бусдаас туслалцаа хүссэн байх хэдий ч тэдний 7,7 хувь нь л өмгөөлөгчид ханджээ.

Мөн шийдвэрлэх оролдлого хийсэн иргэдийн 6,5 хувь нь л бэрхшээлээ шийдвэрлэсэн.



Хөөцөлдөхөө больж орхисон шалтгааны харвал:



Бэрхшээлээ шийдвэрлүүлэхээр оролдлого хийсэн иргэдийн 80 гаруй хувь нь төрийн байгууллагад хандсан байна.



АСУУЛТ

- Энэ дүр зураг бодит байдалтай нийцэж байна уу?
- Иргэдэд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх, боломжийн талаар ямар мэдээллийг нэн түрүүнд хүргэх шаардлагатай вэ?
- Дээрх мэдээллийг ямар сувгаар хүргэвэл илүү үр дүнтэй вэ?